221

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН, ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР
Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024.02.23 № 01/276

танай ____________-ны №____________-т

ДОРНОД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ

Тендер түдгэлзүүлэх тухай

Танай газраас 2024 оны 2 дугаар сарын 7-ны өдөр зарласан "Дорнод аймгийн 13 сумдын эрүүл мэндийн төвд 2024 онд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах" ДОАЭМГ/20240102001 дугаартай тендерийн баримт бичгийн "Багц-34"-т холбогдох гомдлыг "Мөнхийн Тун" ХХК-аас ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянаж байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт заасны дагуу гомдлыг хянан хэлэлцэж шийдвэрлэх хүртэлх хугацаанд уг тендерийн "Багц-34"-т холбогдуулан гаргасан захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилт, тендер шалгаруулалтын баримт бичгийг авах, нээлт хийх үйл ажиллагааг түр түдгэлзүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

Уг тендер шалгаруулалттай холбогдох тайлбар болон үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, тендерийн баримт бичиг, холбогдох бусад материалыг 2024 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГА Б.БИЛГҮҮН

О. Мягмарсүрэн
Т. Тамдолгор
холбогдох
бичиг баримтыг
0000892
бүрдүүлж хүргүүлэх
нь